

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.12.23

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын ХНС бодлогыг хүүг 0.25% бууруулав
- Ирэх онд хүүг 4 биш 2 удаа л бууруулна
- АНУ-ын зах зээлд коррекц орж ирж ханшийн хөдөлгөөн эрүүлжлээ
- Хятадын эдийн засгийн үзүүлэлтүүд сэтгэл гонсойлгосоор
- Хятадын зах зээлийн хувь заяаг зөвхөн төрийн шийдвэр тодорхойлно
- Дэлхий даяар зул сарын баярын амралт тохиож арилжааны идэвх бага байна.

2024 он 12-р сарын 23

Dow Jones	42,840.26
S&P 500	5,930.90
Nasdaq	19,572.60
DAX	19,884.75
FTSE 100	8,084.61
S&P/ASX 200	8,175.80
HANG SENG	19,830.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	1.18%	-2.01%	-3.29%	13.67%	14.59%	19.16%
S&P 500	1.09%	-2.36%	-0.64%	24.34%	24.74%	25.50%
Nasdaq	1.03%	-2.98%	2.99%	30.39%	30.55%	25.04%

2024 оны 12 сарын 23-ны 11:40

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.43%	-2.11%	2.91%	18.70%	19.03%	26.20%
FTSE 100	-0.26%	-2.15%	-2.15%	4.54%	5.03%	9.66%

2024 оны 12 сарын 23-ны 11:40

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	1.31%	-0.93%	-2.64%	7.66%	8.94%	10.14%
Hang Seng	0.47%	0.24%	3.19%	16.40%	21.43%	-14.56%

2024 оны 12 сарын 23-ны 11:40

ЗӨВЛӨМЖ

Техник болон суурь шинжилгээг хослуул:

Техник шинжилгээ: Ханшийн дүрслэл (chart), дэмжлэг ба эсэргүүцлийн түвшин, хэлбэлзэл (volatility) зэргийг ажиглаж арилжааны зөв цагийг тодорхойл.

Суурь шинжилгээ: Компани, салбарын нөхцөл байдал, төлөвлөгөө болон эдийн засгийн өргөн хүрээний мэдээг судал.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Баавгай ичээнээсээ гарч ирэв.

АНУ-ын голлох индекс болох Nasdaq Composite индекс 2.98%, S&P 500 индекс 2.36% тус тус унаж дээд цэгтээ хүрээд байсан зах зээлийг эрүүл болголоо. Нэг өдрийн дотор хүчтэй унаж 8-р сард болсон даваа гарагийн хүчтэй уналттай дүйцэхүйц хэмжээгээр зах зээл уналаа. Гэсэн ч баасан гарагт зах зээл сэргэж зарим компаниудын хувьцаа эргэж алдагдлаа нөхөөд байна.

ХНС-ийн шийдвэр

Энэ оны хамгийн сүүлийн том сэдвийн нэг бол ХНС-ийн хүүгийн шийдвэрийн талаарх мэдэгдэл байлаа. ХНС бодлогын хүүг дахин 0.25% бууруулж энэ жил нийтдээ 1 хувиар бууруулж 4.25-4.5%-ийн хооронд болгосон юм. Гэсэн хэдий ч ирэх онд хүүг 4 удаа бууруулна гэсэн хүлээлт зах зээл дээр байсан ч инфляц өндөр байгаагаас шалтгаалж зөвхөн 2 удаа л буюу 0.5%-иар хүүгээ бууруулна гэж мэдэгдэв. Мөн 2025 оны инфляцын таамаглалыг 2.2-оос 2.5% болгож нэмэгдүүлсэн байна.

Эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг

Эдийн засаг нь 2024 оны 3-р улиралд 3.1%-ийн өсөлттэй гарч, хүлээлтээс давав. Төв банк эдийн засгийн хүчтэй өсөлтийн улмаас хүүгийн хэмжээг яаран бууруулахгүй байхаа мэдэгдсэн. Энэ нь хүүгийн бууралтгүй үед мөнгөний урсгал өндөр хэлбэлзэлтэй зах зээлд орохгүй, зах зээлийн өсөлтөд саад учруулж болзошгүй юм.

Зул сарын баярын амралт

Дэлхий даяар зул сарын баяр тохиож зах зээл амралтын байдалд орлоо. Арилжааны идэвх суларч, магадгүй өнгөрсөн долоо хоногт ихэнх хөрөнгө оруулагч нар өөрсдийн хөрөнгөө заран бэлэн мөнгөтэй болон гарсан байж магадгүй. Энэ долоо хоногт ч мөн заралтууд үргэлжлэх хандлагатай байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал

abliguun published on TradingView.com, Dec 23, 2024 11:19 UTC+8

S&P 500 E-mini Futures, 1D, CME +20.75 (+0.35%) +20.75 (+0.35%)



TradingView



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хувьцааны уналт болон эдийн засгийн нөхцөл байдал эргэлзээ төрүүлсээр.

Хувьцааны зах зээл сулран унаж, эдийн засгийн таагүй мэдээллүүд зах зээлийн итгэлийг буурууллаа. Shanghai Composite индекс 0.7%-иар буурч, CSI 300 0.14%-иар унасан бол Хонг Конгийн Hang Seng индекс 1.25%-иар буурав.

Эдийн засгийн үзүүлэлтүүд сэтгэл гонсойлгож байна.

11-р сарын эдийн засгийн мэдээлэл нь Хятадын эдийн засгийн сэргэлт жигд бус байгааг илтгэжээ.

- Жижиглэн худалдааны борлуулалт жилийн дүнгээр 3%-иар өссөн нь таамагт хүрээгүй төдийгүй 10-р сарын 4.8%-иас буурсан үзүүлэлт байлаа. Энэ нь Хятадын хэрэглэгчдийн зарцуулалт сул байгааг харуулж байна.
- Тогтмол хөрөнгийн хөрөнгө оруулалт 1-11-р сард 3.3%-иар өссөн нь 10-р сарын 3.4%-иас бага үзүүлэлт байв.
- Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт 10.4%-иар буурсан байна.

Хэдийгээр зарим үзүүлэлтүүд сул байсан ч аж үйлдвэрийн үйлдвэрлэл жилийн дүнгээр 5.4%-иар өссөн нь робот, зорчигчийн машин, нарны хавтангийн эрэлт нэмэгдсэнтэй холбоотой байв.

Хятадын зах зээлийг төрийн дэмжлэг л шийднэ.

Шинжээчид Хятад эдийн засгийн өсөлтөө дэмжих нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна. Учир нь шинээр бүрэлдэх Дональд Трампын засаг захиргааны үед АНУ-ын тарифын өсөлт зэрэг сорилтууд тулгарах төлөвтэй байна.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



E EARNINGS WHISPERS		The Most Anticipated Earnings Releases			
		for the month beginning			
		December 16, 2024			
		(only showing confirmed release dates)			
Monday		Tuesday	Wednesday	Thursday	Friday
16	Mitek Mammoth Financial Comcast Networks REC CAT amentum Surgipath Inc. quipt	HEICO RBE ESSA	Micron LENNAR BIRKENSTOCK General Mills JABIL TOBO ABM MillerKnoll Steelcase	Nike FedEx accenture BlackBerry CINTAS DARDEN FACTSET CARMAX EastCell Energy	CARLSVAL WHEELER
23	LIMONEIRA				
30					
06	Key	RPM Prologis Inc. AAR	MSC UniFirst PENGUIN	W-40 Vocality Brands PriceSmart Accolade SimplyGood Helen of Troy	
13		Calavo	citi SYNOVUS BNY	bancorp PNC M&T Bank Infosys F&E TEL	slb REGIONS FASTER TRUIST Huntington Citizens wellsfargo SIOUX ENERGY